



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 47

Дархан

Сүм, хийдийн зөвшөөрөл сунгах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт сүм, хийд байгуулах, зөвшөөрөл олгох, хяналт тавих, сунгах, цуцлах журмын 4 дэх хэсгийг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хавсралтад дурьдсан сүм, хийдийн зөвшөөрлийг сунгасугай.

2. Хугацаа сунгуулсан сүм, хийдийн ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Азжаргал/-д үүрэг болгосугай.

3. Монгол Улсын Үндсэн хууль, Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, жил бүр тайлангаа ирүүлж байхыг сүм, хийдийн удирдлагуудад даалгасугай.

ДАРГА



С.НАСАНБАТ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2021 оны 06 дугаар сарын 17-ны
өдрийн 47 тогтоолын хавсралт

ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААГ СУНГАХ СҮМ, ХИЙДИЙН ЖАГСААЛТ

№	Сүм, хийдийн нэр	Байршил	Тэргүүний нэр	Хугацаа
1	“Долоо дахь өдрийн адвентист” сүм	Дархан сум, 5 дугаар баг өөрийн байр	Д.Дарханбаатар	2022.06.10
2	“Хөвөгч авдар Есүсийн хайр” сүм	Дархан сум 10 дугаар баг Шинэ Дархан Энх-Оршихуй сургалтын төвийн байр	Б.Нэргүйбаатар	2022.06.10
3	Христын чуулганы “Итгэл сүм” ШБ	Дархан сум 14 дүгээр баг, 1-108	Б.Батмөнх	2022.06.10
4	“Нэг довныхон холбоо” ШБ	Дархан сум Өргөө баг, Шинэ үе холбооны байр	Т.Долгормаа	2022.06.10
5	“Шинэчлэл холбоо” сүм	Дархан сум 10 дугаар баг	М.Мөнгөншагай	2022.06.10
6	“Есүсийн алдар” сүм	Дархан сум 6 дугаар баг, 91-р брак	О.Даариймаа	2022.06.10
7	“Вайвэм” дархан монголиа	Дархан сум 15 дугаар баг, Мангирт 3-р хэсэг, 37-р брак	С.Энхтайван	2022.06.10
8	“Дархан эзний цуглаан” сүм	Дархан сум, 6 дугаар баг, Ханжаргалан 2-1а, Зэг төв	Т.Буяндэлгэр	2022.06.10
9	“Есүсийн тосгон” сүм	Дархан сум, 1 дүгээр баг Цэнгэлдэхийн 1-11 тоот	П.Уранбилэг	2022.06.10
10	“Гоц авъяас, зөн билгийн шавь академи”	Дархан сум 5 дугаар баг Худалдааны 2-р гудамж 208 тоот	Г.Оюунгэрэл	2022.06.10
11	“Бал сажаавын номлолт Жавзан Нарохажид” хийд	Дархан сум 14 дүгээр баг 2 хороолол өөрийн байр	Ч.Батгавъяа	2022.06.10
12	“Дархан амьд үг” христийн сүм	Дархан сум 12 дугаар баг Олон улсын худалдааны төв В-1	Д.Дарханбаяр	2022.06.10
13	“Дархан” христийн чуулган	Дархан сум 8 дугаар баг Манхан толгой өөрийн байр	Д.Амгалан	2022.06.10

-----oOo-----

